

## 12

### МОНГОЛ ОРНЫ БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛД

Б.Дэмид

*Түлхүүр үгс: бүсчилсэн хөгжил, баруун бүс, бүс нутгийн онцлог, хөгжлийн төлөв байдал, бодлогын хэрэгжилт, тулгамдсан асуудал, хөгжлийн хандлага, бүс нутаг судлал*

21-р зуунд дэлхийн дахины хөгжлийн хамтран нэгдэх чиг хандлага, түүнийг эсэргүүцсэн тодорхой урсгал чиглэл, даяаршил, дангаарчлалын огтлолцлын орчин дахь Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, тогтвортой тууштай хөгжих хүсэл эрмэлзлэл, түүнийг бодит зүйл болгох зөв арга зам зэргээс ургуулан бодвол улс орноо бүсчлэн хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны асуудалд анхаарлаа нэн сайтар хандуулах зайлшгүй шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Бүс нутгийнхаа хөгжлийн асуудлыг амжилттай шийдвэрлэж ирсэн улс орнуудын туршлагаас үзэхэд бүсчилсэн хөгжлийн тодорхой онол номлолуудад /“Экспортод суурилсан онол”, “Шинэ эдийн засгийн газар зүйн онол”, “Бүс нутгийн хөгжлийн шинэ сонгодог онол” гэх мэт/ тулгуурлаж, тухайн бүс нутгийнхаа онцлогт тохирсон хөгжлийн гарцуудыг тодорхойлон хэрэгжүүлж ирсэн аж. Тухайлбал, Скандиновын орнууд, Швейцарь зэрэг улс тухайн бүсийн байгалын нөхцөл, газар зүйн байрлалыг, Франц улс хөгжлийнх нь ерөнхий төвшинг, ХБНГУ дэд бүтцийнх нь хөгжлийн төвшинг, Англи улс хүн амынх нягтаршлын байдлыг, Португали улс тухайн бүсд хүрч очих нөхцөл боломжийг харгалзан үзсэн байх жишээтэй.

Манай улсын хувьд түүхэн уламжлал талаас нь авч үзвэл, бүсчилсэн хөгжлийн тухай асуудал тийм ч цоо шинэ зүйл биш аж. Байгаль, дэлхийдээ гүн хүндэтгэлтэй хандаж, өөрчлөлт хувьсалтай нь найрсан зохицож, буурь сэлгэн амьдарч, аж төрдөг онцлогтой нүүдэлчин гүрнүүд бүр Хүннүгийн үед газар нутгаа хойноос нь урагш гурван бүсд хувааж байсан ба хожим 1755 онд

Цэцэн хан, Засагт хан, Түшээт хан аймгууд дээр Сайн ноён хан аймгийг нэмж байгуулсан зэрэг нь монголчууд нутаг орноо бүсчилдэг байсан эртний уламжлалтай болохын илэрхийлэл юм. Гэхдээ уг асуудалд гол төлөв бэлчээр усаа зөв оновчтой ашиглах, ган зудаас зайлсхийх, байгалын нөөц, хүчин зүйлүүдийг харгалзан үзэх, мөн нутаг дэвсгэр, засаг захиргааны бүтэцүүдийг өөрчлөх талаас нь хандаж байсан болохоос эдийн засгийн агуулгаар нь хандаж байсан нь бараг үгүй юм. Харин 20 – р зууны дунд үеэс бүс нутгийн асуудалд хөгжлийн талаас нь, шинэлэг байр сууринаас хандаж эхэлсэн байна. 1961 онд монгол-зөвлөлтийн хэсэг эрдэмтэд хоёр орны ШУА-ын даалгавараар Монгол улсад эдийн засгийн мужлал тогтоох судалгаа явуулж, тус улсад Дорнод, Төв, Өрнөд гэсэн эдийн засгийн 3 бүс бүрдэх боломжтой гэж үзээд дорнод бүсд 3, төвийн бүсд 9, өрнөд бүсд 6 аймгийг хамруулсан бүсчиллийн анхны загварыг боловсруулж, тэр үеийн Улсын төлөвлөгөөний комисст хүлээлгэн өгсөн байна. Энэхүү бүсчиллийн асуудлыг цаашид үргэлжлүүлэн судлаж, 1964, 1969, 1973, 1979, 1983 онуудад эдийн засгийн 4-6 бүсүүдийг шинэчлэн тогтоож, тухай тухайн үеийн УААС-г хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөнүүдийг боловсруулахдаа харгалзан үздэг байв.

Монгол улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэн 1990 оноос хойш төр, засгаас улс орноо бүсчлэн хөгжүүлэх талаар тусгайлан анхаарч, бие даасан шинэ бодлого явуулах болов. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хууль, 1996 онд батлагдсан “Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал”, “Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” зэрэг тулгуур баримт бичгүүдэд Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл санаа, ерөнхий чиг хандлыг тодорхой тусгасан бөгөөд улмаар УИХ-аар “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” /2001 он/, “Бүсүүдийн тулгуур төв хотуудыг тогтоох тухай тогтоол”, “Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, /2010 он/, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль” /2003 он/ зэрэг үндсэн баримт бичгүүд батлагдсанаар улс орноо бүсчлэн хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдэж, 2005 онд Засгийн газраас “Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрүүдийг” /2006-2015 он/ батлан гаргаж, улмаар бүсийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо, Бүсүүдийн Зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж байна.

“Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тус орны эдийн засгийн бүсүүдийг Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын гэсэн 5 бүсд хувааж, бүс бүрт харъяалагдах аймгуудыг тогтоосон юм.

Монгол орны баруун бүсийн хувьд байгалын тогтоц, нөөц баялаг, хүн амын үндэс угсаа, соёл уламжлал, ёс заншил, оюуны чадавхаараа бусад бүсүүдээс ялгарах нилээд онцлогтой бүс нутаг юм. Тус бүсд Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгууд харъяалагдах бөгөөд хойт талаараа ОХУ, өмнөд талаараа БНХАУ –тай хиллэн оршдог. Нутаг дэвсгэрийн хувьд

415.5 кв.км талбайтай буюу улсынхаа нийт нутгийн 26.5 %-ийг эзэлдэг. Нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг уулархаг өндөр газар зонхилох бөгөөд нийт нутгийн 90 гаруй хувийг далайн төвшинөөс дээш 1000 м – ээс өндөр газар нутаг эзэлдэг. Энэ бүс нутагт монгол орны байгалын бүхий л бүс, бүслүүрүүд багтдаг ба мөнх цаст өндөр сүрлэг уул нурууд, цэвэр цэнгэг устай түргэн урсгалт гол мөрөнүүд, цэцгэнд хучигдсан цэлгэр уудам хээр тал, нүд алдам элсэн говь зэрэг байгалийн бүхий л өнгө төрх нэг дор цогцолсон хосгүй үзэсгэлэнтэй газар нутаг юм. Энд монгол орны хамгийн өндөр цэг – Алтай таван богд, Хүйтэн уул /дтд 437.4 м/, хамгийн том нуур – Увс нуур /3350 км.кв/, хамгийн том элсэн манхан – Монгол элс, Бөөрөг дэл оршдог. Энэ бүс нутагт улсын нийт дархан цаазат, тусгай хамгаалалттай газрын 45.9 % нь байдаг бөгөөд улаан номонд орсон 30 гаруй төрлийн ан амьтан, 20 гаруй төрлийн жигүүртэн шувуу, 10 гаруй зүйлийн ургамал байдаг.

Тус бүсд өнөөгийн байдлаар улсын нийт хүн амын 16.4% нь оршин суудаг, олон үндэстэн ястны өлгий нутаг юм.

Баруун бүсийн хөгжлийн давуу талуудад байгалын өвөрмөгц цогцолбор, ховор амьтан, ургамалын төрөл зүйл бүхий өргөн уудам нутаг, хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж болох эдэлбэр газрын харьцангуй их нөөц, байгаль орчиндоо зохицсон, дэлхийд ховор бэлчээрийн уламжлалт мал аж ахуй, түүнд зохицсон нүүдлийн амьдралын өвөрмөгц хэв маяг, соёл иргэншлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж нөхцөл, байгалын баялаг, мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөөц боломж, хөрш орнуудын зах зээлийн арвин багтаамж, хүн амын боловсролын харьцангуй өндөр төвшин, хөдөлмөрч уламжлал, харин хөгжлийн сул талуудад эдийн засгийн өрөөсгөл бүтэц, төвөөс хэт алслагдсан байрлал, дэд бүтцийн хоцрогдол, шинжлэх ухаан технологийн хөгжил доогуур, дэлхийн зах зээлд өрсөлдөх чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх чадвар дорой, цаг агаар, уур амьсгал эрс тэс, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл байгалаас шууд хамааралтай, эрсдэл ихтэй, хүн амын тоо харьцангуй цөөн, тархай бутархай байршилтай, хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал зэргийг хамруулж болох юм.

Нийгмийн шинэ тогтолцоонд шилжсэнээс хойшх 10 гаруй жилийн хугацаанд төр, засгийн зүгээс хот, хөдөөгийн хэт ялгарал гарахаас урьдчилан сэргийлэх, бүс нутгуудын хөгжлийг дэмжих талаар оновчтой, цэгцтэй, тууштай бодлого, бодитой үйл ажиллагаа дутагдсанаас болж, бүс нутгуудын хөгжлийн тэнцвэр алдагдаж, их нүүдэл үргэлжилж, ард иргэд зутарч, өнөөдөр түүний хор уршиг, хүндрэл бэрхшээлийг давах гэж бүх шатандаа оролдож байна.

Сүүлийн жилүүдэд манай орны эдийн засаг сэргэх зарим нааштай хандлагууд бий болж байгаа боловч бүс нутгуудын хөгжилд мэдэгдэм ахиц дэвшил гарч чадахгүй, ард иргэдийн ахуй амьдралын ядуу дорой байдал

үргэлжилж, ялангуяа баруун бүсийн хувьд байдал хүнд хэвээр байна. Тус бүс нутаг нь эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргааны төвшингээрээ улс орны хамгийн хоцрогдолтой муж болон хувирах төлөвтэй болж, ард иргэдийн дунд ажилгүйдэл, ядуурал бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр хэмжээнд байсаар байна.

Ийм учраас тус бүс нутгийн нийгэм, эдийн засгийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, хуримтлагдсан асуудлуудыг тодорхойлж, цаашдын хөгжлийг түргэсгэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсронгуй болгоход бага боловч хувь нэмэр оруулах зорилгоор МУИС – ийн Завхан аймаг дахь Эдийн засгийн салбар сургуулийн дэргэдэх Баруун бүсийн судалгааны төвийн судалгааны баг Азийн судалгааны төвийн дэмжлэгтэйгээр 2006 онд бүсийн нийт аймгуудын хамруулан “Баруун бүсийн нийгэм, эдийн засгийн орчны судалгааг” хийж гүйцэтгэсэн юм. Судалгааг :

1. бүс нутгийн хүн ам зүйн орчин
2. бүс нутгийн төсөв, татварын орчин
3. бүс нутгийн банк, санхүүгийн орчин
4. бүс нутгийн үйлдвэрлэл, худалдаа, ХАА – н орчин
5. бүс нутгийн хөрөнгө оруулалтын орчин гэсэн

чиглэлүүдээр сүүлийн 3 жилийн байдлыг харьцуулан нилээд нарийвчилсан үзүүлэлтүүдээр хийсэн юм.. Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхэд дараах зэрэг болон сөрөг төлөв байдлууд ажиглагдаж байна. .

#### хүн амын хувьд:

хүн амын бууралт саарах, шилжилт, хөдөлгөөний урсгал багасах, хүн амд өсвөр, залуу насныхан зонхилж, идэр насныхан өсөх, эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж, төрөлтийн бууралт саарах, нийт хүн амд эзлэх хөдөлмөрийн насны хүмүүс нэмэгдэж, ажил хайж буй бүртгэлтэй хүмүүсийн тоо өсөх, хүн амын ажил эрхлэлт дэд бүтэц, барилга, уул уурхай, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэндийн салбаруудад бага боловч нэмэгдэх хандлагатай болж, сургуулийн насны хүүхдүүдийн тоо өсч, сургууль завсардалт, бичиг үсэг үл мэдэх явдал тууштай буурсан, мөн мэргэжилтэй ажилчид бэлтгэх, ажил мэргэжилгүй хүмүүст мэргэжлийн чиг баримжаа олгох, тэдгээрийг ажлын байраар хангахад ахиц гарч байгаа,

#### төсөв, татварын хувьд:

үргүй зардал буурч, төсвийн зарцуулалтын хяналт сайжирч, суурь төсөв нэмэгдэж байгаа,

#### банк, санхүүгийн хувьд:

банкны хямралыг давж, банкны бүтцийн өөрчлөлт хийгдэж, үйл ажиллагаа нь эрүүлжин тогтворжиж, ард түмний банкинд итгэх итгэл дээшилж, иргэдийн банкинд дахь хадгаламж өсч, мөнгөний нийлүүлэлт асар хурдтай нэнмэгдэж, санхүүгийн зуучлал хэвийн явагдах болж, банкны сүүлийн үеийн үйлчилгээнүүд нэвтэрч эхэлж, зээл, түүний хууль эрх зүйн орчин сайжирч байгаа,

**үйлдвэрлэлийн хувьд:**

үйлдвэрлэл бага боловч сэргэж эхлэх, үйлдвэрлэлийн салбар, чиглэлүүд нэмэгдэх хандлагатай болж байгаа,

**худалдаа, үйлчилгээний хувьд:**

худалдаа, үйлчилгээний салбар өргөжиж, худалдаа эрхлэгчдийн тоо нэмэгдэж, худалдаа, үйлчилгээний шинэ төрлүүд бий болж, шинэ техник, технологи, арга барил нэвтэрч, зохион байгуулалтын хувьд дэвшил гарч, бөөний төв, бөөний зах, агуулах, супермаркет, хапермаркет, гэрээт борлуулагч, төрөлжсөн салбар дэлгүүрүүдийн тоо нэмэгдэж, үйлчилгээ өргөжин, ялангуяа, зоогийн газар, гоо сайхан, компьютерийн үйлчилгээ хурдацтай нэмэгдэж, шинээр интернетийн, үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрч байгаа,

**ХАА-н салбарын хувьд:**

малын тоо, толгой таван төрөл дээрээ өсч, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц арвин / тус бүсд улсын нийт малын 30 гаруй хувь нь ногддог ба жилд ямааны ноолуур 860 гаруй тн, хонины ноос 5000 гаруй тн, тэмээний ноос 400 тн, үхрийн хөөвөр 100 гаруй тн, адууны хөөвөр 100 тн -ыг бэлтгэж, үхрийн мах 2600 тн, адууны мах 2200 тн, хонины мах 3000 тн-ыг экспортлож, арьс шир, ноос, ноолуур, мах, сүү зэрэг мал аж ахуйн түүхийг эдийг боловсруулах хөнгөн, хүнсний үйлдвэр хөгжүүлэх боломжтой / байгаа,

**хөрөнгө оруулалтын хувьд:**

хөрөнгө оруулалт хийгдэх чиг хандлага сайжирч, хөрөнгө оруулалт анхлан бизнес эрхлэгчид, хөдөөгийн малчид, хөдөө аж ахуй, дэд бүтэц, мэдээлэл технологийн чиглэрээр түлхүү хийгдэж, эх үүсвэрүүд нь гол төлөв янз бүрийн төслөөр дамжин санхүүжигдэж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний түлхэц болж байгаа зэрэг нааштай, эерэг талууд байна. гэвч:

**хүн амын хувьд:**

хүн амын цэвэр өсөлт тууштай буурч, өрхийн тоо эрс цөөрч, гэр бүл салалт эрчимтэй нэмэгдэж, шилжилт хөдөлгөөн бүрэн зогсохгүй, хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх эдийн засгийн идэвхитэй хүн ам буурч, эдийн засгийн идэвхигүй хүн ам өсч, хүн амын ажил эрхлэлтэнд хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад буурч, аж үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрлэл, аж ахуй, бизнесийн салбарын ажиллагсдын тоо өсөхгүй, ажил идэвхитэй хайж буй хүмүүсийн ихэнхийг ямар ч мэргэжил боловсролгүй хүмүүс эзлэж, дээд боловсролтой ажилгүйчүүд эрс олширч, төрийн төсөвт байгууллага, төрийн бус байгууллагад ажиллагсад нэмэгдэхийн сацуу төрийн албан хаагчдын боловсролын түвшин доогуур, сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтанд ахиц гарахгүй байгаа,

**төсөв, татварын хувьд:**

төсвийн захирагч, менежер санхүүгийн ажилтануудын төсөв, татварын талаархи ажил хэргийн болон хууль эрх зүйн мэдлэг боловсрол хангалтгүй, төсвийн зардлын зүйл ангиудын төлөвлөлт оновчтой бус, төсвийн бүтцийг нэмэгдүүлэх, үр дүнг санхүүжүүлэх явдал хангалтгүй, зардлыг зориулалтын бус хэлбэрээр зарцуулах, үргүй зардал гаргах явдал арилаагүй, онцгой албан

татвар, аж ахуй нэгжийн орлогын албан татвар тасрах, буурах тохиолдлол ихтэй, орон нутгийн төсөв болон улсын төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө жигд бус, аймгийн засаг даргатай сумын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн менежер нарын хооронд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэх ажил хэвшээгүй, өртэй гарсан байгууллагуудын өр үүссэн шалтгааныг судлан тогтоох, дутагдлыг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээг тэр бүр авч ажилладаггүй,

**банк, санхүүгийн хувьд:**

зээлийн бүтээгдэхүүний хугацаа богино, хүү өндөр, барьцаанд чиглэгдсэн, /ихэнхдээ 12 сар хүртэлх богино хугацааны зээл давамгайлдаг/, банкны даатгал, орон сууцны санхүүжилтийн үйлчилгээ хязгаарлагдмал, ихэнх зээлдэгч нарын /70-80% нь/ суурь үл хөдлөх хөрөнгө бага, өөрийн хөрөнгийн дийлэнх нь эргэлтийн хөрөнгөд орж явдаг, ихэнх бизнес эрхлэгч, аж ахуй нэгж, ард иргэд зээлийн хөрөнгөөр санхүүжигддэг, голдуу худалдаа үйлчилгээ эрхэлдэг, зээлийн зориулалт, ашиглалт оновчтой, үр ашигтай бус, ганзгын наймаа, ахуйн хэрэгцээгээ залгуулахад чиглэгддэг, банкнаас зээлдэгчдийнхээ талаар хийгдсэн судалгаа хангалтгүй,

**үйлдвэрлэлийн хувьд:**

эдийн засгийн салбарын бүтэц алдагдсан, экспортын баримжаатай үйлдвэр хөгжөөгүй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийдэг үйлдвэр ч олигтой хөгжиж чадаагүй, ихэнх үйлдвэрүүд нь хүчин чадлаараа бүрэн гүйцэд ажиллаж чаддаггүй, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвар сул, үйлдвэрлэл эрхлэх хөрөнгийн эх үүсвэр хомс, зээлийн хүү өндөр, хугацаа шахуу, дэд бүтэц сул хөгжсөн, эрчим хүчний хомсдол тасардаггүй, тээвэрлэлтийн зардал буурдаггүй, үнийн өсөлт зогсдоггүй, дүрэм журмын давхардал, хүнд суртал ихтэй, шинэ технологи, тоног төхөөрөмжийн хангамж муу, нарийн мэргэжлийн боловсон хүчин, ажиллах хүч хүрэлцээгүй, ажиллагсдын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бизнес сэтгэлгээ, мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутмаг,

**худалдаа, үйлчилгээний хувьд:**

худалдааны салбарт чанарын стандартад нийцсэн, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээг хангах, сонголт хийх боломжийг олгох хэмжээний бараа бүтээгдэхүүн нийлүүлэгддэггүй, жижиглэнгийн худалдаа зонхилж, бөөний худалдааны суурь тавигдсан хэдий ч бөөний гэсэн утгаа хадгалахуйц хэмжээнд ажиллаж чаддаггүй, түүхий эд худалдан авах худалдаа, түгээлтийн оновчтой суваг бий болоогүй, бараа бүтээгдэхүүний дийлэнх хувийг төвөөс нийлүүлж байгаа нь худалдаачид, эцсийн дүндээ худалдан авагч нарт хүндээр тусдаг, үйлчилгээний салбарын орчин нөхцөл, чанар муу, үйлчлэгч нарын мэргэжлийн ур чадвар дутмаг, ялангуяа зочид гийчэд, аялал жуулчлалд зориулагдсан үйлчилгээ туйлын хангалтгүй,

**ХАА-н салбарын хувьд:**

мал аж ахуй нь байгалын хүчин зүйлээс хараат хэвээрээ, эрчимжсэн МАА хөгжөөгүй, малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг дээшлүүлэх талаар дорвитой ажил хийгддэггүй, малчид малынхаа ашиг шимийг бүрэн ашиглаж чаддаггүй, зах зээл дээр гаргаж, өндөр үнээр борлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга технолог эзэмшээгүй, цаг уурын хүчин зүйлээс шалтгаалж, ургацын хэмжээ тогтворгүй, газар тариалан эрхлэх тоног төхөөрөмж, усалгааны систем хомс, иргэдийн тариалан эрхлэх сонирхол, үр чадвар дутмаг

**хөрөнгө оруулалтын хувьд:**

гадаадын хөрөнгө оруулалт нь шууд бус байдлаар, төсөл хөтөлбөрөөр дамжин хэрэгждэг, дотоодын хөрөнгө оруулалт гол төлөв улсын төвлөрсөн хөрөнгөөр санхүүжигддэг ба зориулалт нь өрөөсгөл, /барилга, урсгал завсар, машин тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслэл зэрэгт голлон зарцуулагдаж, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр бараг хийгддэггүй /, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх дотоод эх үүсвэр туйлын хомс, аж ахуйн нэгж байгууллагуудын орлогын эх үүсвэр, ашигт ажиллагаа доогуур, төлбөрийн чадвар сул, хөрөнгө оруулалт орж ирэх дэд бүтцийн нөхцөл хүнд, хөрөнгө оруулалтыг татах, түүний зарцуулалтыг оновчтой болгох талаар төр засаг, бүс, орон нутгийн удирдлагын үйл ажиллагаа хангалтгүй зэрэг сөрөг, сул талууд байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлого үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв, онвчтой, үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлэхэд бүс нутаг судлалын ажил онцгой ач холбогдолтой юм.

Бүс нутгийн хөгжлийн асуудлаар эрдэмтэд, судлаачдын санал бодлыг төр, засгийн бодлого, шийдвэрт тусгуулах зорилгоор ШУА –ийн дэргэдэх ББНХДХ - оос санаачлан 1998 онд Ховд, 1999 онд Говь –Алтай, 2000 онд Завхан, 2001 онд Увс, 2002 онд Баян-Өлгий аймагт, 2004 онд нийслэл хотод эрдэм шинжилгээний бага хурлуудыг зохион байгуулсан байна.

Мөн 2007 оны 6-р сард МУИС –ийн Завхан аймаг дахь Эдийн засгийн сургууль дээр Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо, Баруун бүсийн зөвлөл хамтран “Баруун бүсийн эдийн засгийн өсөлтийг дэмжиж, салбарын зохистой бүтцийг бий болгоё” сэдэвт Баруун бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулав.

Бүс нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг томъёолон тодорхойлох талаар проф. Д.Бямбаа, Л.Цэдэндамба, Х.Маам, Д.Рэгдэл, Д.Тэрбиш, Н.Жалбажав, Г.Чулуунбаатар, С.Хаумдас нарын эрдэмтэд, судлаачид их зүйлийг хийсэн байна. Харин ШУА-ын харъяа ҮХХ-ийн хэсэг эрдэмтэдийн 2004 оны 2-р хагаст баруун бүсийн зарим нутгаар хийсэн хэрийн судалгааг эс тооцвол бүс нутгийн хөгжлийн асуудлыг эдийн засгийн шинжлэх ухааны үүднээс үл суурьтай судлаж, үр дүнд нь задлан шинжилгээ хийсэн цогц судалгаа хараахан үгүй байна

Бидний хийсэн судалгааны үр дүнг манай баруун бүс нутгийн хөгжлийн асуудлаар бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, энэ бүст харъяалагддаг аймгуудын удирдлагууд цааш цаашдынхаа үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ харгалзан үзвэл тус бүс нутгийн хөгжлийг жолоог шинжлэх ухааны үндэслэлтэй удирдан залж, эцсийн эцэст хөгжлийн ач холбогдол, үр өгөөжийг нь бүс, орон нутгийнхаа ард иргэдийн амьдралд хүртээлтэй болгоход тус нэмэр болно гэж үзэж байна.

Ер нь манай улсын хэмжээнд, ялангуяа баруун бүсийн хувьд бүсчилсэн хөгжлийн талаар авч хэрэгжүүлж ирсэн арга хэмжээнүүдийн ерөнхий дүр төрхийг харахад хууль, дүрэм, бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөгөө, хурал зөвлөгөөн, төсөөлөл бясалгалын байдал зонхилж, харин асуудалд прагмитик хандаж, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, түүнд тулгуурласан оновчтой шийдэл, тодорхой зохион байгуулалт, бодитой ажил үгүйлэгдэж байгаа нь илэрхий ажиглагдаж байна

21-р зууны дэлхийн хүн төрөлхтний хөгжлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлж буй тогтвортой хөгжлийн /sustainable- development/ эдийн засгийн онолын үндэс нь бүх төрлийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, хэрэглээг байгалийн чадамжаас хэтрүүлэхгүй байх, байгаль орчны нөөцийг өсгөж, оюуны болон экологийн зардлыг нэмэгдүүлэх тухай асуудал бөгөөд үүнийг шийдвэрлэх арга зам нь:

- хүний мэдлэг, оюуны бүтээмж,
- экотехнологийн инноваци,
- гео-эдийн засгийн нэгдэл,
- сайн засаглалын хөгжил гэж үзэж байна.

Хөгжлийн энэ хандлагад НҮБ болон олон улсын гол байгууллагуудын төвшинд ихээхэн ач холбогдол өгч, НҮБ-ын дээд хэмжээний уулзалтаар баталсан Мянганы хөгжлийн зорилтуудыг ч энэхүү хандлагад тулгуурлан дэвшүүлсэн.

Түүнээс гадна өнөөдөр хүн төрөлхтөн аж үйлдвэржилтийн эринийг ардаа орхиж, мэдээлэл, мэдлэг оюуны эрин үед аль хэдийнээ хөл тавьж, дэлхий нийтээрээ “мэдлэгт суурилсан эдийн засгийн” хөгжилд шилжсэн болохыг эрдэмтэд санал нэгтэй цохон тэмдэглэж байна. “Мэдлэгийн эдийн засаг” гэдгийг эрдэмтэд олон янзаар тодорхойлж байгаа боловч тэр нь эцсийн дүндээ эдийн засаг дах “мэдлэгийн хувьсгалын” үр дүн болох бөгөөд эдийн засагт мэдлэгийг бий болгож, түүнийг олж авах, эзэмших, шингээх, дэлгэрүүлэх, ашиглах хурдаар тодорхойлогдох болж байна.

Дэлхийн эдийн засгийн хөгжлийн энэхүү шинэ чиглэл нь хөгжлөөр дорой буурай орнууд хөгжлийн энэ замд цаг алдалгүй орж, хөгжилтэй улс орнуудыг гүйцэх, болж өгвөл эн зэрэгцэх боломжийг олж авахгүй бол бусад улс орнуудаас улам холдон хоцрогдох эрсдлийг дагуулах нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, өнөөдөр дэлхийн шинэ эдийн засаг нь тухайн орон глобал эдийн засагтай хэрхэн инеграцлагдаж, түүнээс байнга суралцах замаар мэдлэгийн болон технологийн хувьсгалыг хир зэрэг хурдан бөгөөд

найдвартай хийж чадсанаас шалтгаалан урьд өмнө байгаагүй хөгжлийн боломжийг олж авах, эсвэл урьд өмнө тохиолдоогүй хоцрогдолд орж, дэлхийн хөгжлөөс бүр мөсөн гээгдэх аюултай тулгарах өрсөлдөөний сонголтыг улс орон бүрийн өмнө тулган тавьж байна.

Тийм болохоор манай орон хөгжлийнхөө, тэр тусмаа бүсчилсэн хөгжлийнхөө стратегийг тодорхойлохдоо өнөөдөр дэлхийн практикт хэрэгжиж байгаа дээрх хөгжлийн хандлага, шинэ чиглэлийг зайлшгүй тооцоолон харгалзах шаардлага ч бий болж байгаа юм.

Дэлхийн улс орнуудын хөгжил маш хурдан өөрчлөгдөж шинэ шинэ шийдлийг шаардах болсон өнөөгийн нөхцөлд бүсчлэн хөгжүүлэх зөв механизм, оновчтой арга замыг гагцхүү шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаануудын үндсэн дээр л тодорхойлох боломжтой бөгөөд уг ажлыг үл ойшоож хойш тавих нь тухайн улс орны болон бүс нутгийн өвөрмөц байдлыг тооцсон хөгжлийн хамгийн үр ашигтай хувилбарыг боловсруулан хэрэгжүүлж, дэлхий нийтийн даяршлын нөхцөлд хөл алдахгүй, тогтвортой хөгжлийн замд тууштай, эрчимтэй нэгдэн нийлэх эрхэм зорилгын хэрэгжилт саарч, улмаар эх орны ирээдүйн хөгжил дэвшилд нөхөж чадашгүй хохирол учруулах төлөвтэй байгааг эрдэмтэд анхааруулсаар байна. 21-р зуунд дэлхийн улс орнууд бүс нутгийн интеграцд нэгдэн орж, хүн төрөлхтний өмнө тулгарч буй глобал асуудлуудад эн тэргүүнд бүс нутгийн эрх ашгийн үүднээс хандан шийдвэрлэх байр суурь давамгайлах болсон өнөөгийн нөхцөлд бүс нутгийн хөгжил нь хоцрогдлоосоо гарч чадахгүй хий эргэж байгаа манай орны хувьд юуны өмнө бүс нутаг судлалыг эрдэм судлалын өндөр төвшинд авч үзэх шаардлага нэгэнт бий болсон бололтой.